

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/63/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он</p>	<p>Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х. Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д. Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б. Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж.....	17
3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН ДАРГА Л.БАЯНБААТАР
ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 32
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020271

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	481,457,096.31	464,169,088.54		
33	АВЛАГА	12,600.00	0.00		
33500	Бусад авлага	12,600.00	0.00		
33510	Байгууллагаас авах авлага	12,600.00	0.00		
35	БАРАА МАТЕРИАЛ	481,444,496.31	464,169,088.54		
35100	Түүхий эд материал	304,154,802.86	341,537,137.86		
35110	Тусгай зориулалттай материал	304,126,963.86	341,230,117.86		
35130	Эм боох материал	27,839.00	307,020.00		
35400	Хангамжийн материал	176,289,693.45	120,631,950.68		
35410	Бичиг хэргийн материал	1,397,450.00	137,700.00		
35420	Аж ахуйн материал	36,637,783.90	60,370,993.90		
35430	Сэлбэг хэрэгсэл	5,283,416.00	5,685,000.00		
35440	Түлш, шатах тослох материал	12,286,259.50	7,644,149.38		
35450	Барилгын засварын материал	75,000.00	16,463,207.40		
35460	Хүнсний материал	23,700.00	32,400.00		
35470	Бусад хангамжийн материал	120,586,084.05	30,298,500.00		
35600	Мал амьтад	1,000,000.00	2,000,000.00		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,655,600,605.58	5,670,189,230.84		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,655,600,605.58	5,670,189,230.84		
39200	Биет хөрөнгө	4,030,074,365.58	5,041,731,390.84		
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,620,866,448.00	4,053,271,343.72		
39202	Хуримтлагдсан элэгдэл	-437,735,742.70	-694,112,359.74		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,624,860,411.00	2,638,913,411.00		
39204	Хуримтлагдсан элэгдэл	-853,514,801.43	-1,007,039,589.71		
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	193,340,992.18	177,606,777.18		
39206	Хуримтлагдсан элэгдэл	-154,257,927.30	-156,207,237.59		
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,938,515.35	51,860,250.35		
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,423,529.52	-22,561,204.37		
39300	Биет бус хөрөнгө	625,526,240.00	628,457,840.00		
39301	Програм хангамж	1,100,000.00	1,100,000.00		
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,100,000.00	-1,100,000.00		
39303	Бусад биет бус хөрөнгө	625,526,240.00	628,457,840.00		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,137,057,701.89	6,134,358,319.38		
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	935,700.00	827,218.73		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	935,700.00	827,218.73		
41300	Өглөг	935,700.00	827,218.73		
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	718,598.73		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	923,100.00	108,620.00		
41360	Бусад өглөг	12,600.00	0.00		
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	12,600.00	0.00		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,136,122,001.89	6,133,531,100.65		
51	Засгийн газрын хувь оролцоо	5,136,122,001.89	6,133,531,100.65		
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	966,643,979.89	966,643,979.89		
51200	Хуримтлагдсан үр дүн	4,168,996,834.79	5,166,864,524.76		
51210	Өмнөх үеийн үр дүн	3,851,287,282.28	4,169,455,426.00		
51220	Тайлант үеийн үр дүн	317,709,552.51	997,409,098.76		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	481,187.21	22,596.00		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,137,057,701.89	6,134,358,319.38		

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,990,989,832.00	2,924,733,060.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	573,894,620.00	1,587,967,560.52
120	Нийтлэг татварын бус орлого	573,894,620.00	1,587,967,560.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	835,229.00	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	835,229.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	549,349,716.00	1,314,248,058.52
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	23,709,675.00	273,719,502.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,417,095,212.00	1,336,765,500.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,275,055,600.00	1,140,082,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,275,055,600.00	1,140,082,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	142,039,612.00	196,683,400.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,500,000.00	0
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,500,712.00	172,954,418.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,467,100.00	11,811,875.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	571,800.00	11,917,107.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,673,280,279.49	1,927,323,962.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,673,280,279.49	1,927,323,962.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,631,504,757.49	1,921,429,488.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	890,629,570.00	884,248,500.73
210101	Үндсэн цалин	565,077,670.00	514,991,601.73
210102	Нэмэгдэл	294,688,600.00	338,764,899.00
210105	Гэрээт ажлын хөлс	30,863,300.00	30,492,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,637,516.00	33,945,992.42
210201	Тэтгэврийн даатгал	13,299,800.00	29,261,492.42
210202	Тэтгэмжийн даатгал	1,400,000.00	1,059,300.00
210203	ҮОМШЮ-ний даатгал	1,120,000.00	847,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	280,000.00	211,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,537,716.00	2,566,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,635,365.00	123,443,868.50
210301	Гэрэл, цахилгаан	7,923,205.00	7,564,549.00
210302	Түлш, халаалт	114,992,112.00	108,069,363.50
210303	Цэвэр, бохир ус	7,720,048.00	7,809,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	106,034,093.86	109,487,511.12
210401	Бичиг хэрэг	2,151,700.00	4,579,050.00
210402	Тээвэр, шатахуун	72,877,107.50	77,620,221.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,397,063.00	2,118,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,608,223.36	25,169,940.00
2105	Нормативт зардал	103,464,565.50	239,100,478.05
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,648,561.00	1,177,219.00
210502	Хоол, хүнс	45,664,700.00	88,618,269.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	56,151,304.50	149,304,990.05
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	94,166,500.00	45,150,516.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,357,700.00	213,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,653,900.00	0
210604	Урсгал засвар	72,154,900.00	44,937,016.00
2107	Томиллолт, зочны зардал	5,237,900.00	7,064,000.00
210702	Дотоод албан томиллолт	5,237,900.00	7,064,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,157,523.00	7,280,308.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	52,210.00	3,072,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	818,000.00	818,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	498,112.00	852,760.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	374,000.00	374,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	330,100.00
210807	Газрын төлбөр	1,327,201.00	1,832,548.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	265,541,724.13	471,708,313.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,619,600.00	132,000,000.00

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,513,500.00	4,284,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	258,408,624.13	335,424,313.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,775,522.00	5,894,474.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,425,000.00	3,306,044.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,425,000.00	3,306,044.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,350,522.00	2,588,430.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,350,522.00	2,588,430.08
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	317,709,552.51	997,409,098.76
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	317,709,552.51	997,409,098.76

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	966,643,979.89	1,075,525.96	3,850,692,943.52	4,818,412,449.37
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	594,338.76	594,338.76
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	966,643,979.89	1,075,525.96	3,851,287,282.28	4,819,006,788.13
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-594,338.75	0	-594,338.75
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	317,709,552.51	317,709,552.51
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	966,643,979.89	481,187.21	4,168,996,834.79	5,136,122,001.89
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	966,643,979.89	481,187.21	4,168,996,834.79	5,136,122,001.89
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	458,591.21	458,591.21
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	966,643,979.89	481,187.21	4,169,455,426.00	5,136,580,593.10
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-458,591.21	0	-458,591.21
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	997,409,098.76	997,409,098.76
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	966,643,979.89	22,596.00	5,166,864,524.76	6,133,531,100.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,417,930,441.00	1,336,765,500.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	835,229.00	3,142,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	835,229.00	3,142,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	835,229.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	835,229.00	0.00
120009	Бусад орлого	0.00	3,142,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,417,095,212.00	1,333,622,900.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,275,055,600.00	1,140,082,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,275,055,600.00	1,140,082,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	142,039,612.00	193,540,800.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,500,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,500,712.00	169,811,818.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,467,100.00	11,811,875.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	571,800.00	11,917,107.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,414,097,241.00	1,301,000,620.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,414,097,241.00	1,301,000,620.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,372,321,719.00	1,294,556,146.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	890,629,570.00	883,529,902.00
210101	Үндсэн цалин	565,077,670.00	514,989,027.00
210102	Нэмэгдэл	294,688,600.00	338,048,875.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,863,300.00	30,492,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,637,516.00	33,945,992.42
210201	Тэтгэврийн даатгал	13,299,800.00	29,261,492.42
210202	Тэтгэмжийн даатгал	1,400,000.00	1,059,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,120,000.00	847,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	280,000.00	211,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,537,716.00	2,566,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,736,635.00	125,167,819.50
210301	Гэрэл, цахилгаан	7,923,205.00	7,564,549.00
210302	Түлш, халаалт	112,093,382.00	109,793,314.50
210303	Цэвэр, бохир ус	7,720,048.00	7,809,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	111,397,175.00	78,134,318.00
210401	Бичиг хэрэг	1,668,000.00	2,356,800.00
210402	Тээвэр, шатахуун	84,754,212.00	54,181,018.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,717,063.00	1,798,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,257,900.00	19,798,200.00
2105	Нормативт зардал	47,190,800.00	87,698,869.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,671,400.00	1,456,400.00
210502	Хоол, хүнс	45,305,000.00	86,242,469.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	214,400.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	147,201,500.00	66,719,557.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	54,317,700.00	10,554,750.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,653,900.00	0.00
210604	Урсгал засвар	72,229,900.00	56,164,807.40
2107	Томилотт, зочны зардал	5,237,900.00	7,064,000.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	5,237,900.00	7,064,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,157,523.00	7,171,688.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	3,072,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	52,210.00	0.00

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	818,000.00	818,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	498,112.00	744,140.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	374,000.00	374,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	330,100.00
210807	Газрын төлбөр	1,327,201.00	1,832,548.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,133,100.00	5,124,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,619,600.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,513,500.00	5,124,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,775,522.00	6,444,474.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,425,000.00	3,856,044.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,425,000.00	3,856,044.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,350,522.00	2,588,430.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,350,522.00	2,588,430.08
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,833,200.00	35,764,880.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,833,200.00	35,764,880.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,833,200.00	35,764,880.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,833,200.00	35,764,880.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,833,200.00	35,764,880.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,833,200.00	-35,764,880.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан / төгрөгөөр /
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,140,082,100.00	1,137,493,669.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,140,082,100.00	1,137,493,669.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,137,370,500.00	1,134,782,069.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	877,755,200.00	877,691,027.00
210101	Үндсэн цалин	515,053,200.00	514,989,027.00
210102	Нэмэгдэл	332,210,000.00	332,210,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,492,000.00	30,492,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,533,100.00	33,945,992.42
210201	Тэтгэврийн даатгал	29,848,600.00	29,261,492.42
210202	Тэтгэмжийн даатгал	1,059,300.00	1,059,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	847,400.00	847,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	211,800.00	211,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,566,000.00	2,566,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,848,500.00	121,129,219.50
210301	Гэрэл, цахилгаан	9,330,700.00	7,564,549.00
210302	Түлш, халаалт	105,048,000.00	105,754,714.50
210303	Цэвэр, бохир ус	8,469,800.00	7,809,956.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,467,900.00	17,467,500.00
210401	Бичиг хэрэг	1,480,200.00	1,480,200.00
210402	Тээвэр, шатахуун	14,061,000.00	14,061,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,638,300.00	1,638,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	288,400.00	288,000.00
2105	Нормативт зардал	30,568,400.00	30,568,313.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,456,400.00	1,456,400.00
210502	Хоол, хүнс	29,112,000.00	29,111,913.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,067,400.00	41,067,330.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,355,800.00	1,355,730.00
210604	Урсгал засвар	39,711,600.00	39,711,600.00
2107	Томилот, зочны зардал	1,961,000.00	1,961,000.00
210702	Дотоод албан томилолт	1,961,000.00	1,961,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,388,500.00	7,171,688.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,106,400.00	3,072,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	818,000.00	818,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	811,100.00	744,140.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	374,000.00	374,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,100.00	330,100.00
210807	Газрын төлбөр	1,948,900.00	1,832,548.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,780,500.00	3,780,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,780,500.00	3,780,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,711,600.00	2,711,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,711,600.00	2,711,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,711,600.00	2,711,600.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,140,082,100.00	1,137,493,669.92
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,140,082,100.00	1,137,493,669.92
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,140,082,100.00	1,137,493,669.92

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	193,540,800.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	193,540,800.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,266,356.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,838,875.00
210102	Нэмэгдэл	5,838,875.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,642,600.00
210302	Түлш, халаалт	3,642,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,720,218.00
210401	Бичиг хэрэг	876,600.00
210402	Тээвэр, шатахуун	39,173,418.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,510,200.00
2105	Нормативт зардал	55,330,556.00
210502	Хоол, хүнс	55,330,556.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,287,107.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,980,000.00
210604	Урсгал засвар	51,437,107.40
2107	Томилот, зочны зардал	5,103,000.00
210702	Дотоод албан томилот	5,103,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,344,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,344,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Онцгой байдлын газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 21/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Онцгой байдлын газар нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний оролцоог уялдуулан зохицуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Учир нь тус байгууллагад дотоод аудитын нэгж байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал болох 1,673.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 33.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 26.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Онцгой байдлын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19 хувиар буюу 997.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Тайлант онд улсын төсвөөс 1,140.1 сая төгрөгийн санхүүжилт, 196.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт нийт 1,336.8 сая төгрөг эх үүсвэр бүрдүүлж оны эцэст 2.6 сая төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн буюу 2021 оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 464.2 сая төгрөг болж 17.3 сая төгрөгөөр буурсан нь ковид-19 цар тахлын онцгой нөхцөл байдал үүсэж зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 351.8 сая төгрөгийн, үнэ хандив тусламжаар 6.3 сая төгрөгийн, дээд газар болон бусад газар нэгжээс 267.4 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авах замаар бэлтгэж бараа материалын данс хооронд 19.9 сая төгрөгийн шилжүүлэх гүйлгээ хийсэн ба үйл ажиллагаандаа 642.8 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,551.2 сая төгрөг болж 1,430.6 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 35.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 1,468.8 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг дээд газраасаа шилжүүлэн авч 44.0 сая төгрөгөөр 2 тээврийн хэрэгслийг дахин үнэлсэн байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 735 дугаар албан бичгээр 19.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгасан ба тээврийн хэрэгслийн дахин үнэлгээтэй холбоотой 98.4 сая төгрөгийн бууруулах гүйлгээ хийгджээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 0.8 сая төгрөг болж 0.8 сая төгрөгөөр өссөн нь татварын тодорхойлолтоор үүссэн бөгөөд татварын байгууллагад төлөх татварын тооцооноос үүссэн болно.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6,133.5 сая төгрөг болж 997.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 0.4 сая төгрөг хаасан бичилт хийсэн ба энэ нь хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой байна. Тайлант онд хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 5,166.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,309.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 169.3 сая төгрөгөөр бууруулж, 1,140.1 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь урсгал зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн гамшгаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,140.1 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,140.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,137.5 сая төгрөгийг зарцуулж 2.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,137.5 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлын зүйл ангийг 0.6 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.2 бусад зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 196.7 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба ЗГНХ,ЗДНХ,Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө ангилалд 172.9 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 23.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 0.08 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. Байгууллагын төсвийн данснаас гадуур аймгийн Засаг даргын тамгын газраас 3.1 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан ба санхүүгийн тайланд тохируулах бичилт хийсэн байна. Нэмэлт санхүүжилтийн орлогоос 5.8 сая төгрөгийг цалингийн нэмэгдэлд, 3.6 сая төгрөгийг түлш халаалтын зардалд, 59.7 сая төгрөгийг хангамж бараа материалын зардалд, 55.3 сая төгрөгийг хоол хүнсний зардалд, 61.4 сая төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 5.1 сая төгрөгийг дотоод томилолтын зардалд, 1.3 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд 1.1 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Онцгой байдлын газар нь 2021 онд нийт 1,483.5 сая төгрөгийн 163 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 0.8 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй 324.7 сая төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн хэрэгжүүлсэн горим сорилын дүнд өр үүсгэсэн 0.8 сая төгрөгийг мэдээлээгүй нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Төсөв захирагч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй.

Онцгой байдлын газрын батлагдсан, тодотгосон төсөв, төсвийн хуваарь зэргийг харьцуулан судлахад тайлант онд босго үнээс давсан худалдан авах ажиллагаа зохион байгуулах цаг хугацаа хангалттай төсөв батлагдсан түлш халаалт, хоол хүнсний зардал байна.

Дээрх зардлын зүйл ангид батлагдсан төсвийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилын дүнд тайлант онд шууд худалдан авах босго үнээс давсан хүнсний материалын худалдан авалт хийхдээ худалдан авах ажиллагааг цаг хугацааны хувьд оновчтой зохион байгуулаагүйгээс 10,139.1 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагаанд шалгарсан бэлтгэн нийлүүлэгчээс бусад бэлтгэн нийлүүлэгчээс 6,409.1 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагааны баримт материалд хүнсний материалын нэр төрлийг бүрэн оруулаагүйгээс 1,571.3 мянган төгрөгийн гэрээнд тусгагдаагүй хүнсний материалын шууд худалдан авалт хийсэн нь Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 9.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 51.7 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг биелүүлсэн талаар албан бичиг нотлох баримт ирсэн боловч тээвэр шатахууны зарцуулалттай холбоотой илэрсэн зөрчил давтагдан гарчээ.

Тайлант онд төсөв захирагч, төсвийн хоёрдугаар гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан буюу ахлах нягтлан бодогч тус тус солигдсон нөхцөл байдлыг харгалзан давтагдан гарсан зөрчилд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах заалтыг хэрэглээгүй болно.

Цаашид аудитын дүн дүгнэлт, илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх зохион байгуулалтын ажлыг оновчтой хэлбэрээр хийж Төрийн аудитын газрын гаргасан дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагад ач холбогдол өгч илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг онцлон дурдъя.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар цалингийн тооцоолол, тээврийн хэрэгслийн сул асаалтын норм тогтоолт, төвлөрсөн халаалтад орохгүй байгаа шалтгаан, халаалтын зуухны норм тогтоолт, ашиглалтын байдалд ажлын зураг авалт хийх, албан хэрэгцээнд ашигладаг автомашины ашиглалт, нярвын бүх төрлийн тайлангийн иж бүрэн байдлыг тус тус анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 97.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 56.7 сая төгрөгийн алдааг залруулж, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21.7 сая төгрөгийн зөрчилд

албан шаардлага хүргүүлж, шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах 18.1 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар тайлант онд 34.9 сая төгрөгийн хөрөнгийн их засвар хийснийг өртөгт шингээн капиталжуулж, 20.9 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй, татварын тодорхойлолтоор байгууллагад төлөх 0.8 сая төгрөгийн өглөгтэй байсныг илрүүлж аудитын хугацаанд нөхөн шивүүлж анхан шатны баримтын шаардлагыг хангуулсан, өглөгийг санхүүгийн тайланд тусган залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Шатахууны тооцоог давтан тооцоход 0.3 сая төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүйгээр зарцуулснаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнээс өндөр үнээр худалдан авалт хийснээс 441.6 мянган төгрөгийн үнийн зөрүү үүссэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т "«Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер болон тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон худалдааны болон техникийн шаардлага нь худалдан авах гэрээний үндсэн нөхцөл болно", 40.3-т "Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана", 40.5-т "Худалдан авах ажиллагаанд мөрдөх гэрээний стандарт нөхцөлийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална", 57 дугаар зүйлийн 57.1-т "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ", Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Тайлант оны 5 дугаар сард галчид олгосон 6.5 сая төгрөгийн нүүрсний анхан шатны баримтыг нягтлан бодох бүртгэлийн баримтад архивлаагүй, Байгууллагын данс бүртгэлд байдаг албан хэрэгцээнд ашигладаг DAEWOO.K7C6F маркийн (улсын дугаар 01 01 ГАО) галын автомашины спидометрийн заалт тайлант онд 784 километр буюу 862.4 мянган төгрөгийн гүйлтээр тасарсан, LANDCRUISER 200 маркийн суудлын автомашины оны эхний спидометрийн заалт өмнөх онд аудит хийсэн эцсийн заалтаас 30,043 километр буюу 11.1 сая төгрөгийн гүйлтээр тасарсан байхад хувийн хэрэгт тэмдэглэгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төрийн санд байршдаг бүртгэлийн дансаар дамжуулаагүй 3.1 сая төгрөгийн зарцуулалт хийсэн нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6-т "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-аас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах 18.1 сая төгрөгийн 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**
 - 1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд бүртгэгдсэн 0.8 сая төгрөгийн өрийг бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт мэдээлээгүй, харилцагч байгууллагатай тооцоо нийлэх асуудалд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
 - 1.2. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах
2. **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**
 - 2.1. **Илрүүлэлт:** Тайлант онд шууд худалдан авах босго үнээс давсан хүнсний материалын худалдан авалт хийхдээ худалдан авах ажиллагааг цаг хугацааны хувьд оновчтой зохион байгуулаагүйгээс 10.1 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагаанд шалгарсан бэлтгэн нийлүүлэгчээс бусад бэлтгэн нийлүүлэгчээс 6.4 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагааны баримт материалд хүнсний материалын нэр төрлийг бүрэн оруулаагүйгээс 1.6 сая төгрөгийн гэрээнд тусгагдаагүй хүнсний материалын шууд худалдан авалт хийсэн бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулах гэрээ, түүний нэмэлт өөрчлөлт хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
 - 2.2. **Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалтыг мөрдөж худалдан авах ажиллагааг оновчтой зохион байгуулах, бэлтгэн нийлүүлэгчтэй тайланд оны өөрчлөлт нэмэлт материал авах нөхцөлийг гэрээнд тусгах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Онцгой байдлын газар	10	97.3	3	56.7	2	0.8	3	21.7	2	18.1